



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: mlsp@mongolnet.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2020.10.26 № 3/3078
танай _____-ны № _____-т

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

Хамтран ажиллах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих, хамгааллыг сайжруулахад салбар бүрийн оролцоо чухал билээ. Тиймээс дээрх чиглэлээр тухайн салбар, орон нутагтаа манлайлан ажиллаж, амжилт гаргасан байгууллага, иргэдийг шалгаруулж, бүтээлч идэвх санаачлагыг дэмжин, тэргүүний сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сайшаан урамшуулж, алдаршуулах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-ийг шалгаруулах журмыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Журмын 4.1.6-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт”-ыг танай яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл нэр дэвшүүлэхээр заасан.

Иймд яамныхаа дэд зөвлөлийн дэргэд ажлын хэсэг байгуулан уг төрөлд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулж, 1-2 байгууллагын материалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 11 дүгээр сарын 23-ны дотор ирүүлэхийг хүсье.

Түүнчлэн тус журмын 2.1.1 дэх хэсэгт заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах оны шилдэг дэд, салбар зөвлөл” төрөлд танай дэд зөвлөл, мөн бусад төрөлд танай салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нэр дэвших боломжтой тул журмыг сурталчилан хамтран ажиллахыг хүсье.

Энэ асуудлаар тус яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн 260202, 263018 утсаар холбогдоно уу.

Хавсралт 8 хуудастай.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Г.ӨНӨРБАЯР

156202912



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 01


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.28, Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын 3.7, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг"-ийг шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (Ц.Ганчимэг), дэд, салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА  С.ЧИНЗОРИГ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  С.РЭГЗЭН



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон
тооны бус зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 18-
ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОНЫ ШИЛДЭГ”-ИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих, хамгааллыг сайжруулах чиглэлээр тухайн салбар, орон нутагтаа манлайлан ажиллаж, амжилт гаргасан байгууллага, иргэдийг шалгаруулж, бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлэх, тэргүүний туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сайшаан урамшуулж, алдаршуулахад оршино.

1.2. Журам нь Монгол Улсын байгууллага, иргэн бүрт тэгш үйлчилнэ.

ХОЁР. ШИЛДГИЙГ ШАЛГАРУУЛАХ ТӨРӨЛ

2.1. Оны шилдгийг дараах төрлөөр шалгаруулна:

- 2.1.1. Оны шилдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд, салбар зөвлөл;
- 2.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй оны шилдэг боловсролын байгууллага;
- 2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг эрүүл мэндийн байгууллага;
- 2.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллага;
- 2.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг төрийн болон төсөвт, орон нутгийн өмчит байгууллага;
- 2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага;
- 2.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт;
- 2.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө нийгмийн зүтгэлтэн;
- 2.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний манлайлагч төрийн бус байгууллага.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шилдгүүдийг шалгаруулахад дараах шалгуур үзүүлэлтийг баримтална:

3.1. Оны шилдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд, салбар зөвлөл:

3.1.1. Зөвлөлийн дүрмийн дагуу хурлаа тогтсон хугацаандаа зохион байгуулж хэвшсэн байх;

3.1.2. Дэд, салбар зөвлөлийн тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувьтай;

3.1.3. Салбар, орон нутгийн удирдлага, ажилтнуудад зориулан хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт, нөлөөллийн ажил тогтмол зохион байгуулдаг;

3.1.4. Хууль тогтоомж, дүрэм журмын төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангадаг;

3.1.5. Салбар, орон нутгийн хэмжээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх талаар тодорхой санаачилга гарган ажиллаж байгаа;

3.1.6. Тухайн онд салбар, байгууллагын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 11 дүгээр зүйл, "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам техникийн шаардлага MNS 5682:2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009"-ыг баримтлан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчинг бүрдүүлэх талаар санаачилга гаргасан.

3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй оны шилдэг боловсролын байгууллага:

3.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлсэн;

3.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг элсэлтийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн;

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад шаардлагатай сургалтын арга технологийг судлан, сургалтандаа нэвтрүүлэх талаар санаачилгатай ажиллаж байгаа;

3.2.4. Хүмүүнлэг, энэрэнгүй ёс суртахуун, хүүхдийн эрх, ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулдаг;

3.2.5. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх талаар тодорхой санаачилга гарган ажиллаж байгаа;

3.2.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн багшлах ур чадварын сургалтад багш ажилтнуудаа хамруулдаг.

3.3. *Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг эрүүл мэндийн байгууллага:*

3.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй үйлчилгээний орчин бүрдүүлсэн;

3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зааврыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа;

3.3.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх талаар тодорхой санаачилга гаргаж, ханган ажиллаж байгаа;

3.3.4. Тухайн онд салбар, байгууллагын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 11 дүгээр зүйл, "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам техникийн шаардлага MNS 5682:2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009"-ыг баримтлан Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчинг бүрдүүлэх талаар санаачилга гаргасан.

3.4. *Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллага:*

3.4.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүлж байгаа;

3.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон хүртээмжтэй, түгээмэл загвар бүхий ажлын байр бий болгосон;

3.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үр өгөөжтэй төсөл хөтөлбөр, арга хэмжээнд биет болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн;

3.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг тогтмол худалдан авдаг;

3.4.5. Тухайн онд салбар, байгууллагын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 11 дүгээр зүйл, "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам техникийн шаардлага MNS 5682:2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009"-ыг баримтлан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчинг бүрдүүлэх талаар санаачилга гарган хангаж ажилласан.

3.5. *Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг төрийн болон төсөвт, орон нутгийн өмчит байгууллага:*

3.5.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүлж байгаа;

3.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон хүртээмжтэй, түгээмэл загвар бүхий ажлын байр бий болгосон;

3.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх холбогдох хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар санаачлагатай гарган, тодорхой үр дүнд хүрсэн;

3.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авч дэмжлэг үзүүлж байгаа;

3.5.5. Байгууллагын удирдлага, ажилтнуудад зориулан хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт, нөлөөллийн ажил тогтмол зохион байгуулдаг;

3.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлээр төр, төрийн бус болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн;

3.5.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үр өгөөжтэй төсөл хөтөлбөр, арга хэмжээнд биет болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг;

3.5.8. Тухайн онд салбар, байгууллагын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 11 дүгээр зүйл, "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам техникийн шаардлага MNS 5682:2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009"-ыг баримтлан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчинг бүрдүүлэх талаар санаачилга гаргасан.

3.6. *Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт*

3.6.1. Бүтээн байгуулалтын ажилдаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 11 дүгээр зүйл, "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам техникийн шаардлага MNS 5682:2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009"-ыг баримтлан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн;

3.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангаж, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлсэн.

3.7. *Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага:*

3.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар нийгэмд эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд идэвх санаачлагатай ажиллаж, сайн туршлага, тулгамдаж буй асуудлуудын талаар цаг алдалгүй, түргэн шуурхай, үнэн бодитой мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлдэг;

3.7.2. Тухайн онд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар хамгийн олон цагийн нийтлэл нэвтрүүлэг, мэдээ мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэсэн;

3.7.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх талаар тодорхой санаачилга гарган ажиллаж байгаа;

3.7.4. Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, оролцооны талаар реклам сурталчилгаа, нөлөөллийн хөтөлбөр хэрэгжүүлсэн;

3.8. Оны шилдэг хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө нийгмийн зүтгэлтэн

3.8.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сайн сайхны төлөө сайн дурынхны хөдөлгөөнийг манлайлан, нийгэмд тустай үйл ажиллагааг санаачлан зохион байгуулсан;

3.8.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулсан

3.8.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үр өгөөжтэй төсөл хөтөлбөр санаачилж, хөрөнгө оруулалт хийсэн;

3.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний манлайлагч төрийн бус байгууллага

3.9.1. Хөгжлийн бэрхшээлтэй 5-аас доошгүй хүнийг байнгын ажлын байраар хангасан;

3.9.2. Ажлын байр болон ажлын албатай;

3.9.3. Байгууллагын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байх;

3.9.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах, эрх, оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлээр төсөл, хөтөлбөр санаачлан амжилттай хэрэгжүүлсэн;

3.9.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэсэн нөлөөллийн тогтмол ажил зохион байгуулдаг.

ДӨРӨВ. НЭР ДЭВШҮҮЛЭХ

4.1. Дараах эрх бүхий байгууллага нэр дэвшүүлнэ:

4.1.1. "Оны шилдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд, салбар зөвлөл"-ийг Ерөнхий сайдын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөлийн ажлын алба;

4.1.2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй оны шилдэг боловсролын байгууллага"-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл;

4.1.3. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг эрүүл мэндийн байгууллага"-ыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл;

4.1.4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллага”-ыг Монголын ажил олгогч эздийн холбоотой зөвшилцөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар;

4.1.5. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг төрийн байгууллага”-ыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар;

4.1.6. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт”-г Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл;

4.1.7. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага”-ыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын ;

4.1.8. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө нийгмийн зүтгэлтэн”-ыг Төрийн бус байгууллагууд зөвшилцөн;

4.1.9. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний манлайлагч төрийн бус байгууллага”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл.

ТАВ. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

5.1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-т нэр дэвшүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ:

5.1.1. Дэмжиж, нэр дэвшүүлсэн байгууллагын шийдвэр, албан бичиг;

5.1.2. Нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох шалгуурыг хангаж байгааг нотлох тайлбар, тайлан, зураг;

5.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал, дэмжлэгийг нотлох баримт;

5.1.4. Хувь хүн бол иргэний үнэмлэхний, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

ЗУРГАА. ШАЛГАРУУЛАХ

6.1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй оны шилдэг”-ийг дараах үе шаттайгаар шалгаруулна:

6.1.1. Нэгдүгээр үе шат: Жил бүрийн 10 сарын 15-аас 10 дугаар сарын 30-ны хооронд “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг” шалгаруулах журмыг сурталчлах, энэхүү журмын 4.1-д заасан нэр дэвшүүлэх эрх бүхий байгууллага тухайн төрөлд нэр дэвшихээр ирүүлсэн материалыг хүлээн авна.

6.1.2. Хоёрдугаар үе шат: 11 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд материалаа ирүүлсэн байгууллага, иргэнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилна.

6.1.3. Гуравдугаар үе шат: 11 дүгээр сарын 16-аас 12 дугаар сарын 1-ний хооронд энэхүү журмын 4.1-д заасан эрх бүхий байгууллага нэр дэвшигчийг

шалгаруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөлийн ажлын албанд ирүүлнэ.

6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр "Оны шилдгийг шалгаруулах салбар дундын хороо" /цаашид "хороо" гэх/, Журмын 4.1-д заасан эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй оны шилдэгт нэр дэвшүүлэх ажлын хэсэг" /цаашид "ажлын хэсэг" гэх/ байгуулагдана. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын оролцоог заавал хангаж, хараат бус, бодитой шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлсэн байна.

6.3. Ажлын хэсэг тухайн төрлийн шалгаруулалтад оролцохоор ирсэн байгууллагын материалыг хүлээн авч шалгаруулан, 1-2 нэр дэвшигчийн материалыг хороонд ирүүлнэ.

6.4. Хороо төрөл тус бүрээс зөвхөн нэг нэр дэвшигчийг сонгон шалгаруулна.

6.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөлийн ажлын алба "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг"-ийг нийтэд зарлах арга хэмжээг Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийн үеэр зохион байгуулна.

6.6. Оны шилдгээр шалгарсан байгууллага, хувь хүнд Хүндэтгэлийн өргөмжлөл, цом гардуулна.

6.7. Оны шилдгүүдийг шалгаруулах ёслолын үйл ажиллагааг Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз болон бусад олон мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар шууд дамжуулна.

6.8. Хүндэтгэлийн цом, өргөмжлөлийг олны танил, нэр хүнд бүхий улс төрчид, нийгмийн зүтгэлтэн гардуулна.

6.9. Оны шилдгээр шалгарсан байгууллага, хувь хүний тухай сэтгүүл гаргаж, олон нийтэд сурталчилна.

___оОо___